

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

Монгол Улсын 2019 оны 11, 12 дугаар сард экспортлох стратегийн хүнсний нэр, төрөл, тоо хэмжээ тогтоох тухай

Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 329 дүгээр тогтоол, Хүнсний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлийн 2019 оны ... дүгээр сарын ...-ны өдрийн хуралдааны ... дүгээр зөвлөмжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем”-д үндэслэсэн гадаад худалдааны барааны ангиллын жагсаалтад нийцүүлэн 2019 оны 11, 12 дугаар сард экспортлох стратегийн хүнсний нэр, төрөл, тоо хэмжээг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг “Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох журам”-ын дагуу хуулийн хугацаанд зохион байгуулахыг ажлын хэсгийн дарга /Т.Гантогтох/-т, зөвшөөрлийг хууль, тогтоомж, энэхүү тушаалд нийцүүлэн олгож ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргад тус тус даалгасугай.

3. Тушаалыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэн, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх арга хэмжээ авахыг Хуулийн хэлтэс /Э.Цолмонжаргал/-т үүрэг болгосугай.

Гарын үсэг

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн
сайдын 2019 оны .. дугаар сарын .. -ны
өдрийн .. дугаар тушаалын хавсралт

2019 ОНЫ 11, 12 ДУГААР САРД ЭКСПОРТЛОХ СТРАТЕГИЙН ХҮНСНИЙ НЭР
ТӨРӨЛ, ТОО ХЭМЖЭЭ, АНГИЛЛЫН КОД

№	Стратегийн хүнсний нэр	Төрөл	БТКУС-ын код	Нийт тоо, хэмжээ
1	Дулааны аргаар боловсруулсан мах	Үхрийн мах	1602.50.00	1700 тн
2		Хонины мах	1602.90.00	975 тн
3		Ямааны мах	1602.90.00	475 тн
	НИЙТ			3150 тн